



137Page



138Page



139Page

Загалмай

-The Crucifixion-

- Тайлбарлагч** Нэгэн өдөр Есүс дагалдагч нарын хамт Гетсман цэцэрлэг руу явцгаав.
- Есүс** Та нар энд унталгүйгээр намайг иртэл сэрүүн залбираад хүлээж байгаарай.
- Тайлбарлагч** Дагалдагч нартаа ингэж хэлээд Есүс цэцэрлэгийн гүн рүү орж Бурхан аавын өмнө өвдөг сөгдөн чин сэтгэлээсээ залбирав.
- Есүс** Ааваа, зовлонгийн аягыг надаас холдуулаач. Гэхдээ Та миний хүслээр бус Өөрийн хүслээр хийгээрэй.
- Тайлбарлагч** Есүсийг залбирах үед тэнгэр элч нар буун ирж Түүнд хүчийг өгч үйлчлэв. Есүс залбирч дуусаад дагалдагч нар руугаа буцан иртэл тэд унтай байлаа.
- Есүс** Та нар ганцхан цаг ч сэрүүн байж намайг хүлээж чадсангүй юу? Сорилтонд орохгүйн тулд сэрүүн байж залбирцгаа.
-
- Тайлбарлагч** Хэсэг хугацааны дараа, дагалдагч нарын нэг болох Иудас сэлэм агссан цэргүүдтэй хамт ирэв. Иудас Иерусалимын удирдагч нарт Есүсийг 30 мөнгөн зоосоор зарсан байв. Тэгээд цэргүүдэд ингэж хэлэв.
- Иудас** Миний үнсэх хүнийг очиж бариарай! Тэр хүн бол Есүс.
- Тайлбарлагч** Иудас Есүст ойртон ирж Түүнийг үнсэв. Цэргүүд Есүсийг барин явцгаав.
-
- Тайлбарлагч** Есүсийг баригдан явж тахилч нарын өмнө байцаагдав.
- Ахлах тахилч** Чи өөрийгөө Бурханы Хүү гэлүү?
- Есүс** Тийм. Би бол Бурханы Хүү мөн. Би үхэвч амилан Бурханы баруун гарт залрах бөгөөд үүл хөлөглөн дахин ирэхийг харах болно.
- Тайлбарлагч** Есүсийн үгийг сонссон ахлах тахилч ихэд уурлан хашгирав.
- Ахлах тахилч** Чи Бурханыг доромжилж зүрхэлнэ гэнээ !! Чамайг огтхон ч өршөөхгүй дээ !!
- Тайлбарлагч** Эцэст нь ахлах тахилч болон ард түмний удирдагч нар Есүсийг алахаар хуйвалдав. Хүмүүс Есүсийн нүүр рүү нулимаж түүнийг цохиж байв. Бас түүнийг хараан зүхэв.
-



140Page

Тайлбарлагч Дараагийн өдрийн өглөө, хүмүүс Есүсийг Пилатын өмнө аваачив. Ахлах тахилч болон удирдагч нар Пилатад Есүсийг буруутган ховлов. Тэр үед ч Есүс юу ч хэлсэнгүй. Харин Пилат Есүсийг ямар ч гэм буруугүй болохыг мэдэв. Тэр үед, баярын үеэр нэг гэмт хэрэгтнийг сулладаг заншилтай байв. Заншилын дагуу Пилат ард түмнээс асуув.


Пилат Та нар гэмт хэрэгтнээ хэнийг суллахыг хүсэж байна вэ? Барабыг уу? Есүсийг үү?

Хүмүүс Барабыг !! Барабыг !! Барабыг суллахыг шаардаж байна.

Тайлбарлагч Маш олон хүмүүс ингэж хашгирав. Бараб бол хүн алж хоригдсон гэмт хэрэгтэн байлаа.

Пилат За яахав! Тэгвэл би энэ хэрэгт ямар ч хамаагүй шүү. Та нар хүссэн учир, хариуцлагыг нь өөрсдөө хүлээгээрэй!

Тайлбарлагч Эцэст нь Пилат Барабыг суллаж, Есүсийг ташуурдан цовдлох шийдвэр гаргав.



141Page

Тайлбарлагч Цэргүүд Есүст улаан хувцас өмсгөн өргөст титэм толгойд нь зүүлэн тэгээд Есүсийг өвдөг сөгдүүлэн доог тохуу хийцгээв.

Цэргүүд За Иудейн хаан минь, эсэн мэнд байх болтугай..

Тайлбарлагч Цэргүүд улаан хувцасыг тайлж Есүст Өөрийнх нь хувцасыг өмсгөв. Загалмайд цовдлохоор Түүнийг туун явав. Есүс Өөрийнхөө цовдлогдох загалмайд үүрэн Голгатын толгод өөд явав. Хүнд модон загалмайд үүрээд явж байсан Есүс чулуунд бүдрэн газарт сөхрөн уначихав.

Цэргүүд Хурдан бос! Хурдан яв гээд байна!!

Тайлбарлагч Цэргүүд эцэст нь тэрүүгээр өнгөрч явсан Симон гэгчид хүчээр загалмайд үүрүүлэн цааш явцгаав.



142Page

Тайлбарлагч мачимне 예수님이 골고다 언덕에 도착하셨습니다. 병사들은 예수님의 옷을 벗겼어요. 그리고 손과 발에 커다란 못을 박아 십자가에 매달았어요. 병사들은 예수님의 옷을 제비 뽑아 서로 나눠 가졌어요. 예수님의 십자가 위에는 '유대인의 왕'이라는 글씨가 씌어 있었어요. 고통을 참으시며 예수님이 말씀하셨습니다.

Есүс Ааваа, энэ хүмүүсийг уучлаач. Энэ хүмүүс юу хийж байгаагаа мэдэхгүй байна.



143Page



144Page

.....

Тайлбарлагч Хэсэг хугацааны дараа, дэлхий харанхуйд автагдав. Есүс загалмай дээрээс чангаар ингэж хашгирав.

Есүс Миний Бурхан, Миний Бурхан, намайг юунд орхив,

Тайлбарлагч Есүс газар дээр Өөрийнх хийх ажил бүгд дууссан гэдгийг мэдэж байв.

Есүс Бүгд биеллээ.

Тайлбарлагч Есүс ингэж хэлээд нас барав. Яг тэр үед, Иерусалим дахь сүмийн том хөшиг дээрээсээ хоёр хэсэг урагдав. Голгатын толгод хүчтэйгээр доргин чичирж хад хоёр хэсэг хуваагдав. Хүмүүсийн гэм нүглийн төлөө Бурханы Хүү Өөрийгөө өргөн нас барсан юм.